



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/85

Мандалговь

Г

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 13 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан соёл урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хориглосугай.

Хоёр. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй газруудын зөвхөн архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал 09:00-15:00 цаг байхаар мөрдүүлсүгэй.

Гурав. Захирамжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), аймгийн Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) болон холбогдох байгууллага, аж ахуй нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010263